

Соёлын сайдын 2022 оны 10 дугаар
сарын 6-ны өдрийн А/348 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

**ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫГ АЙМАГ,
НИЙСЛЭЛИЙН ХАМГААЛАЛТЫН ЗЭРЭГЛЭЛД НЭР
ДЭВШҮҮЛЭХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Түүх, соёлын үл хөдлөх дурсгал /цаашид “дурсгал” гэх/-ыг аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх дурсгалыг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулж, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг тодорхойлсон байна.

**Хоёр.Дурсгалыг аймаг, нийслэлийн хамгаалалтын
зэрэглэлд нэр дэвшүүлэх**

2.1.Дурсгалыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга өмчийн хэлбэр харгалзахгүй аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлнэ. Дурсгал хоёр ба түүнээс дээш сумын нутаг дэвсгэрийг дамнан оршиж байгаа бол дурсгалын ихэнх хэсэг байрлаж байгаа сум, дүүргийн Засаг дарга бусад сум, дүүргийн Засаг дарга нартай зөвшилцөн нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулна.

2.2.Аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх дурсгал нь дараах шаардлагад нийцсэн байна:

2.2.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт байх;

2.2.2.түүхэн үйл явдлыг гэрчлэх, эсхүл өнгөрсөн үеийн нийгмийн хөгжлийн хувьсал, өөрчлөлтийг илэрхийлж чадах шинж төрхийг хадгалсан байх;

2.2.3.ижил төрлийн дурсгалын нийтлэг хэв шинжийг хадгалсан байх;

2.2.4.соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санд бүртгэгдсэн байх;

2.2.5.сум, дүүргийн хамгаалалтын зэрэглэлтэй байх.

2.3.Унаган газраас нь зөөж, аюулгүй орчинд шилжүүлэн байрлуулсан дурсгалыг аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэхгүй.

2.4.Тодорхой газар нутаг, орон зайн ой санамжийг хамгаалах зорилгоор архивын баримтад үндэслэн боловсруулсан зураг төслийн дагуу анхны төрх байдлаар нь сэргээн босгосон дурсгалын аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлж болно.

2.5.Сум, дүүргийн Засаг дарга хувийн өмчийн дурсгалыг аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх бол өмчлөгчтэй нь урьдчилан зөвшилцсөн байна.

2.6.Сум, дүүргийн Засаг дарга дурсгалыг аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх албан бичгийг энэ журмын 2.2-т заасан шаардлагад нийцсэн болохыг нотлох баримт болон гэрэл зургийн хамт аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

Гурав.Саналыг хянан шийдвэрлэх

3.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн албан бичиг болон холбогдох бусад баримт бичгийг хүлээн авч, бүрдлийг хянаж үзээд шаардлагад нийцсэн бол саналын хамт Соёлын өвийн үндэсний төвд уламжилна.

3.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ журмын шаардлагад нийцээгүй, бүрдэл дутуу, эсхүл газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дурсгалыг нүүлгэн шилжүүлэх болон чөлөөлөхөөр төлөвлөгдсөн бол албан бичгийг холбогдох баримт бичгийн хамт буцааж болно.

3.3.Соёлын өвийн үндэсний төв аймаг, нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн албан бичиг, холбогдох баримт бичгийг хүлээн авч, дурсгал тус бүрийн эх төрх, бүрэн бүтэн байдлын талаар танилцуулга бэлтгэж, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжилна.

3.4.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэр дэвшүүлсэн дурсгалыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 46.2-т заасан Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, санал дүгнэлт гаргуулна.

3.5.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 3.4-т заасан санал дүгнэлтийг үндэслэн дурсгалд аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэл тогтоох шийдвэр гаргана.

3.6.Мэргэжлийн зөвлөлөөс дурсгал нь энэ журамд заасан шаардлагад нийцээгүй тухай санал, дүгнэлт гарсан тохиолдолд ирүүлсэн хүсэлтийг холбогдох тайлбарын хамт аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

Дөрөв.Бусад зүйл

4.1.Эвдэрч, устсан дурсгалыг аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлээс хасах асуудлыг Соёлын өвийн үндэсний төвийн саналыг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

Соёлын сайдын 2022 оны 10 дугаар
сарын 6-ны өдрийн А/348 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл /цаашид “Дурсгалт зүйл” гэх/-ийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд нь дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлнэ.

1.3.Эх төрх, бүрэн бүтэн байдлаа харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн хувьд өндөр ач холбогдолтой, ур хийцийн хувьд ховорт тооцогдох нөхцөл нь үнэт дурсгалт зүйлийн үндсэн шалгуур болно.

Хоёр.Үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх

2.1.Үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх дурсгалт зүйл нь дараах шаардлагад нийцсэн байна:

- 2.1.1.эх хувь байх;
- 2.1.2.тухайн төрлийн дурсгалт зүйлийн гол төлөөлөл байх;
- 2.1.3.Монголчуудын язгуур эрх ашигт харшлахгүй байх;
- 2.1.4.өмчлөлийн маргаангүй байх;
- 2.1.5.судалгаа, эрдэм шинжилгээний эргэлтэд орсон байх;
- 2.1.6.соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй байх.

2.2.Монгол Улсын түүхэнд гарамгай гавьяа байгуулсан төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, урлаг, соёлын алдартан зэрэг гавьяат үйлстэнд зориулан төрөөс тусгайлан захиалж, үйлдвэрийн аргаар бүтээлгэсэн дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлж болно.

2.3.Энэ журмын 2.1, 2.2-т зааснаас бусад үйлдвэрийн аргаар ижил хэлбэр, хэмжээтэй, олон тоогоор бүтээсэн, түгээмэл дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэхгүй.

2.4.Өмчлөгч, эзэмшигч энэ журмын 2.1, 2.2-т заасан шаардлага хангасан дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх саналаа дор дурдсан баримт бичгийн хамт Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлнэ:

- 2.4.1. өргөдөл, эсхүл албан бичиг;
- 2.4.2. энэ журмын 2.1, 2.2-т заасан шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
- 2.4.3. дурсгалт зүйлийн гэрэл зураг, холбогдох бусад зүйл.

2.5. Соёлын өвийн үндэсний төв энэ журмын 2.4-т заасан баримт бичгийн бүрдлийг хянаж хүлээн авна. Бүрдэл дутуу баримт бичгийг хүлээж авахгүй.

Гурав. Саналыг хянан шийдвэрлэх

3.1. Соёлын өвийн үндэсний төв үнэт зэрэглэлд нэр дэвшүүлсэн дурсгалт зүйлийн холбогдох мэдээллийг байгууллагын цахим хуудаст ажлын 10 хоног байршуулж, олон нийтэд танилцуулна.

3.2. Төрийн болон орон нутгийн өмчөөс бусад дурсгалт зүйлийг шашны болон уламжлалт дэг ёс, хүндэтгэн үзэх бусад шалтгааныг харгалзан өмчлөгч, эзэмшигчийн хүсэлтийн дагуу энэ журмын 3.1-д заасан цахим хуудаст байршуулахгүй байж болно.

3.3. Соёлын өвийн үндэсний төв энэ журамд заасан баримт бичгийг бүрдүүлэн соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.4. Энэ журмын 3.3-т заасан баримт бичгийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, санал дүгнэлт гаргуулна.

3.5. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 3.4-т заасан санал дүгнэлтэд үндэслэн, дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад оруулах талаар шийдвэр гаргана.

3.6. Энэ журамд заасан шаардлагыг хангаагүй тухай Мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлт гарсан бол дурсгалт зүйлийн нэр дэвшүүлсэн баримт бичгийг Соёлын өвийн үндэсний төвд буцаан хүргүүлнэ.

3.7. Соёлын өвийн үндэсний төв буцаагдсан баримт бичгийг дурсгалт зүйлийн өмчлөгч, эзэмшигчид холбогдох тайлбарын хамт буцаан хүргүүлнэ.

3.8. Өмчлөгч, эзэмшигч нь дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлсэн саналыг хянан шийдвэрлэх явцад өмчлөх эрхийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй. Хэрэв өмчлөх эрхийг шилжүүлэх шаардлага үүссэн бол энэ тухай Соёлын өвийн үндэсний төвд яаралтай мэдэгдэнэ.

3.9. Энэ журмын 3.8-д заасны дагуу өмчлөх эрх шилжих тохиолдолд дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлсэн саналыг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоож, холбогдох баримт бичгийг өмчлөгч, эзэмшигчид нэн даруй буцаан хүргүүлнэ.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх ажлыг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацааг баримтлан зохион байгуулна.

4.2. Үнэт дурсгалт зүйлийн зэрэглэл тогтоосон дурсгалт зүйлийг олон нийтэд сурталчлах ажлыг Соёлын өвийн үндэсний төв, түүний өмчлөгч, эзэмшигч болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулна.

--- о О о ---